



ГУРВАНСАЙХАН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
Н.АДЬЯАСҮРЭН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016-11-18

№ 01/178

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хурээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар нийт 17,148,691.00 /арван долоон сая нэг зуун дөчин найман мянга зургаан зуун ерэн нэг/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Аудитын хамрах хугацаанд нийт 3,422,150.00 төгрөгийн хүнсний материалыг орцын жишиг нормоор тооцоогүй, хяналтгүй зарцуулж зардалд тайлагнасан байна.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2008 оны 267 тоот тушаалаар баталсан ... Хүний илчлэгийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Нийт 13,726,541.00 төгрөгийн үндсэн хөрөнгийг /машины граж, хуучин барилга, мотоцикл/ холбогдох байгууллагын шийдвэрлгүйгээр үрэгдүүлсэн, хөрөнгийн дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 312. /Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг худалдах, шилжүүлэхэд энэ хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авна/, мөн хуулийн 73.2 /Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дугээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох

119000712

бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Холбогдох журам, жишиг орцын нормын дагуу хүнсний материалын зарцуулалтанд хяналт тавих, сар бүр тооцоо бодож баримтжуулж хэвших, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх.
2. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоос өмнө үрэгдүүлсэн хөрөнгийн шалтгааныг тогтоож шийдвэрлэх, төлбөр тооцоог хийж дуусгах, шаардлагатай бол холбогдох албан тушаалтныг хууль хяналтын байгууллагад шийлжүүлэн шийдвэрлүүлэх
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Гурван сайхан сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Н.Адъясурэн, нягтлан бодогч Д.Баярцэнгэл нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АХЛАХ АУДИТОР



Б.ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ *Д.Адъясурэн* Н.АДЬЯСУРЭН

НЯГТЛАН БОДОГЧ *Д.Баярцэнгэл*

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавсан албан шаардлага, төлберийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” эзж заасны дагуу хариуцаж албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.